




ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт





ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2022 онд: **6%**,
Инфляци: 2022 онд: **8.2%**,
Урсгал тэнцэл: 2022 онд: **-10.2%**-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2021 оны тайланд прогноз хийсэн байна.

Эх сурвалж: <https://bit.ly/30pG2Et>


ДНБ-ий өсөлт: 2022 онд: **7.5%**
Инфляци: 2021 онд: **7.3%**,
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2022 онд: **-8.5%**- Олон улсын валютын сан (ОУВС)-ийн тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <https://bit.ly/3qx1ORq>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 1-р сарын байдлаар (358.30) тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 42.1 хувиар өссөн бол, зарлага 66.3 хувиар нэмэгдэж төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 358.30 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 202.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.




Ам.долларын ханш өмнөх сараас 0.40 төгрөгөөр өсчээ.

Нэгдүгээр сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс -0.46 төгрөгөөр буурч, өмнөх сартай харьцуулахад 0.40 төгрөгөөр буурч 2849.36 төгрөг болов. 1-р сард гадаад валютын нөөц 3.9 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас -9.64 оны эхнээс 13 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 9.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.




Инфляцийн түвшин 14.6%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2022 оны 1-р сарын байдлаар өмнөх сараас 2 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 14.6 хувиар, оны эхнээс 13.4 хувь өсөв. 2022 оны 1-р сард өмнөх оны мөн үеэс 14.6 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 21.3 хувь (мах, махан бүтээгдэхүүн 23.9 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 16.9 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 7.8 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 9.6 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 15.8 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 10.6 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 21.1 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.




Гадаад худалдааны тэнцэл 16.9 сая.ам долларын ашигтай гарав.

2022 оны нэгдүгээр сард нийт барааны эргэлт 1096 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 0.24 хувиар нэмэгдсэн бол экспорт өмнөх сараас 15.6 хувь буурч, импорт өмнөх оны мөн үеэс 21 хувиар нэмэгдэж гадаад худалдааны тэнцэл 16.9 сая ам.долларын ашигтай гарав.



1-Р САРЫН ОНЦЛОХ: ДНБ



Эх сурвалж: www.mongolbank.mn

ДНБ 2021 оны 4-р улирлын байдлаар (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 22.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 42,459 тэрбум төгрөгөөр нэмэгдэж эдийн засгийн өсөлт 15.7 хувиар өсөв. Дотоодын нийт бүтээгдэхүүн (үйлдвэрлэлийн аргаар тооцсон) 2021 оны эхний улиралд урьдчилсан гүйцэтгэлээр оны үнээр 9.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.7 (22.5%) их наяд төгрөгөөр, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 3.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 496.7 (15.7%) тэрбум төгрөгөөр тус тус өслөө. ДНБ-ий 2021 оны эхний улиралд эцсийн хэрэглээнд 67.1 хувь, хөрөнгийн нийт хуримтлалд 29.7 хувь, цэвэр экспортод 3.2 хувь нь зарцуулагдаж, өмнөх оны мөн үеэс эцсийн хэрэглээ 21.1 пунктээр, хөрөнгийн нийт хуримтлал 3.5 пунктээр буурчээ.

САРЫН ОНЦЛОХ

НИЙТ ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ 21.3 ХУВИАР НЭМЭГДЖЭЭ

- Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2021 оны 12 дугаар сарын эцэст 20.9 их наяд төгрөг болов. Энэ нь өмнөх сарынхаас 618.0 (3.1 хувь) тэрбум, өмнөх оны мөн үеийнхээс 3.7 (21.3 хувь) их наяд төгрөгөөр нэмэгджээ. Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 50.8 хувь нь иргэд, 47 хувь нь хувийн байгууллага, 1.3 хувь нь төрийн, 0.9 хувь нь санхүүгийн болон бусад байгууллагынх аж. Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл өнгөрсөн 12 дугаар сарын эцэст 17.9 их наяд төгрөг болж, өмнөх сарынхаас 598.5 (3.5 хувь) тэрбум, өмнөх оны мөн үеийнхээс 3.9 (28.2 хувь) их наяд төгрөгөөр нэмэгдсэн байна. Зээлийн өрийн үлдэгдлийн 85.5 хувийг хэвийн зээлийн өрийн үлдэгдэл эзэлж, энэ нь өмнөх оны мөн үеийнхээс 4.6 нэгж хувиар нэмэгджээ.

ИПОТЕКИЙН ЗЭЭЛД 103 ТЭРБУМ ТӨГРӨГ ХУВААРИЛААД БАЙНА

- Монголбанк болон бусад банкаас хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээлийн хөтөлбөрөөр энэ онд 700 орчим тэрбум төгрөгийн зээл олгоно. Оны эхний 2 сарын санхүүжилтэд төв банк, бусад банкны эх үүсвэрээр 103 тэрбум төгрөгийг хөтөлбөрт оролцогч банкуудад хуваарилаад байгааг Монголбанк мэдээллэв. Хөтөлбөр хэвийн үргэлжилж байгаа тул зээл хүссэн иргэн өөрийн харилцагч банкандаа хандан хүсэлт гаргаж боломжтой. Өнгөрсөн онд гэхэд 1,012 тэрбум төгрөгийн зээлийг 13 мянга гаруй өрхөд олгосон байна.

Эх сурвалж:

- Статистикийн бюллетень, 1-р сар 2022 он, Үндэсний статистикийн хороо
- Статистикийн бюллетень, 1-р сар 2022 он, Монголбанк
- www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn